

**ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-ЫН, ШУТИС-ИЙН ХАРЬЯА Ш.ОТГОНБИЛЭГИЙН
НЭРЭМЖИТ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ
2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Дээд боловсролын тухай хуулийн 7-р зүйлийн 7.3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/79 дугаар тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот “Журамд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, А/195 тоот “Босго оноо тогтоох тухай”, ШУТИС-ийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2019-2020 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам”-ыг тус тус баримтлан Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын, Шинжлэх ухаан, Технологийн их сургууль (ШУТИС)-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэн суралцуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орцны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн Удирдах Зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэн суралцуулна.
- 1.3. Технологийн сургуульд элсэн суралцахаар хүсэлт гаргагч, элсэлтийн ажлыг удирдан зохион байгуулах Элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.4. Элсэлтийн комисс нь энэхүү журмыг баримтлан сургууль, мэргэжлийн танилцуулгыг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх, Монголын их, дээд сургуулиудын консорциумаас томилогдсон элсэлтийн комисстой хамтран бусад аймгуудаас оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулах, элсэхийг хүсэгчдийн материалыг шалгах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулах, элсэлтийн мэдээ, тайланг холбогдох газруудад гаргаж өгөх эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

ХОЁР. ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ

- 2.1. Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуульд оюутан элсүүлэхдээ Технологийн сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон оюутан элсүүлэх хяналтын тоо болон БСШУСЯ-ны харьяа Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноог үндэслэн элсүүлнэ.
- 2.2. Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийн бүртгэл болон хуваарь сонголтыг Монголын Их Дээд сургуулиудын Консорциум /МИДСК/ зохион байгуулах ба 2019 оны 08-р сарын 12-наас эхлэн нэмэлт элсэлтийг <http://elselt.erdenetis.edu.mn/> хаягаар бүртгэж, тус сургуулийн элсэлтийн комисс зохион байгуулна.
- 2.3. Технологийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгч өөрийн сонирхсон бүлэгт заасан хичээл бүрээр Элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ) өгч, хөтөлбөрт тавигдах босго онооны болзлыг хангасан байна. Үүнд:

ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ БҮЛЭГ, БОСГО ОНОО

Бүлэг	Хөтөлбөрийн нэр	Ерөнхий шалгалтын хичээлүүд ба босго оноо	Суралцах хугацаа (жил)	Сургалтын хэлбэр
I	072401 Уул уурхайн ашиглалтын технологи	Математик 500, Физик 400 эсвэл Физик 500, Математик 400	4-4,5	Өдөр
	071304 Цахилгааны инженер		4-4,5	Өдөр, Эчнээ
	061304 Мэдээллийн технологи		4-4,5	Өдөр
	071501 Механик инженер		4-4,5	Өдөр, Эчнээ
	071601 Авто инженер		4-4,5	Өдөр
II	072402 Ашигт малтмал баяжуулалтын технологи	Математик 500, Физик 400 эсвэл Физик 500, Математик 400 эсвэл	4-4,5	Өдөр, Эчнээ
	071503 Металлурги, металын технологи 2+2	Хими 500, Математик 400 эсвэл Математик 500, Хими 400	4-4,5	Өдөр
	ШУТИС-ийн бакалавр инженерийн сургалтын хөтөлбөр 2+2	Математик 450, Физик 400 эсвэл Физик 450, Математик 400 эсвэл Хими 450, Математик 400 эсвэл Математик 450, Хими 400	4-4,5	Өдөр
	Инженерийн бэлтгэл хөтөлбөр (Орос, Англи)	Математик 400, Физик 400 эсвэл Физик 400, Математик 400 эсвэл Математик 400, Орос хэл 400 эсвэл Математик 400, Англи хэл 400	1	Өдөр

- 2.4. Бүртгүүлэгч бүлэгт заасан хичээл бүрээр авсан ЭЕШ-ын оноогоор бүртгүүлэх бөгөөд өндөр оноотой хичээлийн оноогоор тухайн бүлэгт бүртгүүлэгчдийн жагсаалтад эрэмбэлэн заагдсан хөтөлбөрүүдээс сонгуулж элсүүлэн суралцуулна.
- 2.5. Элсэгчдийн нийт оноо тэнцсэн тохиолдолд эхлээд хоёрдугаар хичээлээр авсан оноог харьцуулах бөгөөд шаардлагатай бол гүйцэтгэлийн хувийг харьцуулж шийдвэрлэнэ.
- 2.6. Технологийн сургуулийн дэргэдэх Ахлах сургуулийн сурагчид, Мэргэжлийн боловсрол олгох сургалт, инженерийн бэлтгэл ангид суралцагч нар тус сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт элсэхийг хүсвэл ЭЕШ-ыг математик, физик, хими хичээлээр өгч болох ба аль нэг хичээл нь 400 түүнээс дээш оноо авсан тохиолдолд элсүүлэн суралцуулна.
- 2.7. 2018, 2019 онд ЭЕШ-ыг математикийн хичээлээр өгч 500 болон түүнээс дээш оноо авсан бөгөөд дараах болзол хангасан суралцагчийг урилгаар элсүүлэн суралцуулна.
- 27.1. Математик, физик, хими, мэдээлэл зүй, сэтгэх чадварын олимпиадад аймаг, улсад эхний 5 байр эзэлсэн; 2018, 2019 онд техник-технологийн улсын олимпиадад эхний 5 байр эзэлсэн;
- 27.2. Гар бөмбөг, сагсан бөмбөг, шатар, теннис зэрэг спортын төрлөөр спортын мастер, дэд мастер цолтой;
- 27.3. Сүүлийн 2 жилд урлагийн аль нэг төрлөөр бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож медаль хүртэж байсан.

- 2.8. Дээд боловсролтой иргэн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэж хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүсвэл дээд боловсролын дипломыг үндэслэн шалгалтгүйгээр элсүүлж, суралцуулна.
- 2.9. Цагийн /оройн/ сургалтад дээд боловсролтой болон техникийн боловсролтой иргэнийг элсүүлэн суралцуулна. Сургалтын бүртгэл 2019 оны 08 дугаар сарын 20-ноос 9 дүгээр сарын 05-ны хооронд сургуулийн сургалтын албанд явагдах бөгөөд элсэлтийн шалгалтыг 09 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулж авна.
- 2.10. Бакалаврын цагийн (Эчнээ) сургалтад дээд боловсролын болон техникийн боловсролтой иргэнийг элсүүлэн суралцуулна. Эчнээ сургалтын бүртгэл 2019 оны 09 дүгээр сарын 16-наас 10 дугаар сарын 15-ны хооронд сургуулийн сургалтын албанд явагдах бөгөөд элсэлтийн шалгалтыг 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж авна.
- 2.11. Элсэгчдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг:
- Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолын 4, 5, 6 дугаар бүлэг, 2018 оны 46-р тогтоолын 2-р заалтууд;
 - Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолын хавсралт Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журмын 5.1.1 заалт¹;
 - Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 111 дүгээр тогтоолын 3 дахь заалт;
 - Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх ШУТИС-ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуульд суралцах нийтлэг журмын 11 дүгээр бүлэг журмуудаар тухайн элсэгчийн Технологийн сургуульд суралцах хугацааны сурлагын амжилтыг харгалзан тус тус шийдвэрлэнэ.

ГУРАВ. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭН АВАХ

- 3.1. Суралцах эрхийн бичиг авсан, сургалтын төлбөрөө бүрэн төлсөн элсэгчдийг 2019.08.12–2019.08.26-ны өдрүүдэд Технологийн сургууль дээр бүртгэн авч Сургалтын гэрээ байгуулна. Элсэгчид бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
- Технологийн сургуульд элсэхийг хүссэн өргөдөл;
 - Ерөнхий шалгалтын онооны батламж хуудас, МХБШ-ын хуудас;
 - Суралцах эрхийн бичиг;
 - Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
 - Бүрэн дунд буюу түүний дараах боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт;
 - Сурагчийн хувийн хэрэг; 3x4 хэмжээний цээж зураг 4%;
 - Сургалтын төлбөр төлсөн баримт;
 - ЭМД-ын дэвтэр;
 - Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71-р тогтоол, 2018 оны 46-р тогтоолуудын дагуу сургалтын төлбөр төлөхөөр материал бүрдүүлсэн элсэгчид (Сургалтын төлбөр болон оюутны хөгжлийн зээл авах суралцагчид) төлбөрийн зөрүүгийн урьдчилгаа болох 250000 төгрөгийг сургуулийн дансанд тушаасан баримт;

¹ Бүлэгт заасан хичээлийн аль нэг 600 ба түүнээс дээш оноотой байх

- 3.2. Суралцах гэрээ байгуулсан элсэгчдэд 2019.08.19-2018.08.26-ны өдрүүдэд хичээл сонголт хийх бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын хичээл 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдөр эхэлнэ.
- 3.3. Хяналтын тоонд багтан бакалаврын хөтөлбөрт элсэн суралцах болзол хангагчид эрүүл мэндийн үзлэгт орж оюутны эрүүл мэндийн хуудас нээлгэнэ.
- 3.4. Суралцах эрхийн бичиг авсан боловч 2019.08.12-2019.08.26-ны өдрүүдэд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг сургалтын гэрээ байгуулахаас татгалзсан гэж үзэж суралцах эрхийн бичгийг нь хүчингүй болсонд тооцно.

ДӨРӨВ. ЭЛСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ

- 4.1. Математик, физик, химийн хичээл тус бүрээр элсэлтийн ерөнхий шалгалтад 700-аас дээш оноотой элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 100%, 650-699 оноотой бол 50%, 600-649 оноотой бол 30% хөнгөлнө.²
- 4.2. БСШУСЯ-наас тогтоосон олон улсын олимпиадад оролцож 1-ээс 3-р байр эзэлсэн элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 100% хөнгөлнө.
- 4.3. Улс, бүсийн олимпиадад оролцсон элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 1-р байрт шалгарсан бол 100%, 2-р байрт шалгарсан бол 75%, 3-р байрт шалгарсан бол 50%, 4-р байрт шалгарсан бол 30%, 5-р байрт шалгарсан бол 15 хувь хөнгөлнө.
- 4.4. Элсэгчийн 4.1, 4.2, 4.3 дахь хөнгөлөлт давхардсан тохиолдолд аль нэгийг нь сонгоно.
- 4.5. Элсэгчдэд олгох сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг нотлох баримтыг үндэслэн сургуулийн захирлын тушаал гаргана. Энэхүү тушаалыг үндэслэн хөнгөлөлт олгоно.
- 4.6. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгох захирлын тушаалыг нэг хичээлийн жилд нэг удаа гаргана.
- 4.7. Технологийн сургуулийн бакалаврын сургалтыг төгсөгч хоёр дахь дээд боловсрол эзэмших сургалтад элссэн бол сургалтын төлбөрийг эхний хичээлийн жилд 20 хувиар хөнгөлнө.

СУРГУУЛИЙН ХАЯГ:

Орхон аймаг, Эрдэнэт хот, Технологийн сургууль.

ХАРИЛЦАХ УТАС:

757-73418 Элсэлтийн комиссын дарга

757-73416, 99352968 Элсэлтийн комиссын нарийн бичгийн дарга

757-73318, 99351831 Сургалтын алба

Е-МАЙЛ ХАЯГ:

techinst@erdenetmc.mn

ВЕБ ХАЯГ :

<http://eit.edu.mn/>

<https://www.must.edu.mn/mn/>

<http://elselt.erdenetis.edu.mn/>

ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ:

Бүртгэлийн хураамж, сургалтын төлбөрийн урьдчилгааг хийх:

Дансны дугаар: Орхон аймаг дахь Капитрон банк -3007000002

² Хичээлийн жилийн нэг улиралд суралцагчид олгох мөнгөн дүнгийн хэмжээ хөтөлбөрийн 17 багц цагийн сургалтын төлбөрөөс илүүгүй байна.

Хүлээн авагчийн нэр: Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль
Гүйлгээний утга. Элсэгчийн овог, нэр, регистрийн дугаар